

### III. Монголын ойрхи түүхийн асуудал

#### 1911 ОНЫ БОГД ЖАВЗАНДАМБААС ОРОСЫН БААТАР ЦАГААН ХААНД ИЛГЭЭСЭН ЗАХИДЛЫН ТУХАЙД

Д.Хүүхэнбаатар

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим

**Өгүүллийн товч утга:** 1911 онд Богд Жавзандамба хутагтаас Оросын хаанд илгээсэн захидалд бүх шинжилгээ хийн, тухайн үеийн Монголын удирдагчдын баримталж байсан бодлогыг тодорхойлохыг оролдов.

**Түлхүүр үг:** Тусгаар тогтнол, их улсыг түших, харилцан туслалцах.

1911 онд Богд Жавзандамба хутагтаас Оросын хаанд илгээсэн захидалыг хэн үйлдэв гэдэг асуудал гарна. Тэгвэл нэр заан Жавзандамба, Халхын Түшээт хан Дашням, Сэцэн хан Навааннэрэн, Засагт хан Содномравдан, Сайн ноён хан Намнансүрэн нар хичээнгүйлэн<sup>1</sup> хэмээн өөрсдийгээ дурьджээ. Эд бол үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцлийн<sup>2</sup> нэрт зүтгэлтнүүд байлаа. Тэдний улс төрийн үйл ажиллагаа, тэмцлийг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай байна. 1911-1912 оны тэмцлийг хувьсгал гэх нь бий. Тэгвэл хувьсгалчид болох нь байна. Энэ захидаас үзэхэд оршин тогтнож буй нийгмийн харилцааг халж солих санаа өчүүхэн ч байхгүй. Харин урьдын ёс заншлаа хамгаалан шашнаа мандуулахыг эрхэм болгосон байна. Энэ тэмцлийг нийт монгол үндэстний харийг эсэргүүцсэн үндэсний хөдөлгөөн гэх нь илүү оновчтой санагдана. Ингэх нь түүний түүхэн ач холбогдлыг бууруулах, үгүйсгэх явдал отхон ч биши. Хөдөлгөөн тэмцлийг хөдөлгөх гол хүч нь ардууд гэдэг миний бодоход ардаас гадаад нийгмийн бусад бүлэглэл өргөн оролцсон нийт үндэсний хөдөлгөөн байв. Монгол үндэсний үзэл хүчтэй гарч, Шинэ засгийн бодлого гэгчийг үл зөвшөөрөн мэдэгдсэн байна. Захидалд ийн өгүүлсэн аж. Манай халхын дөрвөн аймаг монголчууд эртнээс янагш шарын шашин шүтэн өөрсдийн хэв суртлаар явтал хожим нь Манж хаанд шүтсээр 200 илүү он Монгол хан, ван засгууд өөр өөрийн албат арддаа эзэн болж газар орны ашгийг өөртөө здэлж маш амар тайвнаар аж төрж<sup>3</sup> байсан байна. Манжийн үед бие даасан хараат холбоотын шинжтэй харьцаж биээ авч, дүүрч явж чадсан байв. Манж хаанд шүтсээр 200 илүү жил болсоноо дурьдаад Шинэ засгийн дүрэм хэмээн нэрийдэж завшаад хятад түшмэд эрхийг барьж улсын хэргийг элдвээр самууруулахын дотор монгол газрын ашиг тариа хэмээх зэргээр эзлэн хуучин хэв суртлыг халж эрх хүчнийг бууруулан бүрэлгэх нь үлэмж үнэхээр гашуун<sup>4</sup> монголын тэр үеийн байдлыг ийнхүү тодорхойлжээ.

Богд хутагт бол төр шашныхаас хамгийн түрүүнд "Шинэ засгийн бодлого"-ын мөн чанарыг ойлгож тэмцэж эхэлсэн шашин төрийн зүтгэлтэн мөн. "Богд гэгээн нь XX зууны босгыг алхахад зөвхөн шашин номын бясалгагч их ламтан төдий бус хорвоогийн эрээн бараан амьдралд ихэд хутгалдан, улс төрийн хэрэг явдлын наад цаад нарийн учрыг доторлосон шаггүй том зүтгэлтэн болсон байв"<sup>5</sup> хэмээн судлаачид дүгнэж байгаад санаа нийлж байна. XX зууны эхний 10-аад жилд Богд улс хүчтэй ажиллаж бие даасан хүчирхэг тэмцэгч болжээ. 1911 оноос төрийн хэрэг, тусгаар тогтнолын төлөө тэмцэж эхэлсэн гэх нь үзтэл буруу. Дурьдан буй захидаас урьд Богд үйл ажиллагаагаа идэвхтэй

<sup>1</sup> УТА. А4-1-25.2

<sup>2</sup> Ж.Болдбаатар. Түүх зулсан он жилүүдийн ойллого. боть II . УБ. 2003. 152. 162-167

<sup>3</sup> УТА. А4-1-25.2

<sup>4</sup> Мөн тэнд

<sup>5</sup> Монгол улсын түүх. УБ., 1999. 194т

явуулж үндэсний эрх чөлөө тусгаар тэмцлийн тэргүүн болон тодорсон байна. Энэ явцад Их улсын /хаант орос/ түшиж, тусгаар тогтох гэсэн бодлого бат суужээ. Тэр чиг шугамаа туштай баримталсаныг түүхэн хэрэг явдлууд баттай нотолж өгдөг. Бүр хойно Александр I хаан хувь заяагаа үзүүлэхээр тусгай элч бодгод илгээжээ. Богд хар чулуундаа үзээд хаан газар сайгүй мөрдөгдөж маш их зовлон зүдгүүрийг туулна<sup>6</sup> гэсэн үнэхээр мэдсэн эрсхэн хариу өгчээ. Хоёр хааны хооронд төрийн болон хувийн итгэл харилцаа ойр байсны бас нэг шинж мөн. Тусгаар тогтносон Монгол улсыг байгуулах санааг анх хаана хэзээ сэдсэн юм бэ гэсэн асуудал тавигдсан байна.

1900 онд Богд Жавзандамба хутагтаас оросын цагаан хаанд нууцаар хүн илгээж, бичиг захидал, бэлэг сэлтийг хүргүүлэн монгол улсын манжаас тусгаарлан тусгаар улс болгох зорилготой байгаагаа мэдэгдээд энэ хэрэгт Орос улсаас цэрэг зэвсэг, улс төрийн харилцааны арга хамтатгасан таван зүйлээр туслахыг хүсчээ. Ингэж Орост хүн явуулсныг Богдын багш Ёнзор Хамба, сайн ноён хан Цэрэндорж хоёроос өөр хэн ч мэдэхгүй, маш нууц зохион байгуулсан байна. 1909 онд Богд гэгээн нэгэн нууц Лүндэн буулгаж "Эдүгээ манай монгол шашин төрөө бататган газар орноо хамгаалж, өнө удаанаар амар жаргалтай суухыг бodoх цаг болжээ. Зүгээр сууж, энэ тухай ч алдаж өнгөрүүлбээс улс үндэстэн, шашин мөхнө гэжээ. Эрхтэй жаргалтай суух байтугай элдэв зовиур үзэж, газар шороогоо ч эзэгнэж чадахгүйд хүрнэ. Энэ учрыг мэдсээр байж би, та бүгдэд эс сануулбаас монгол тоотон бүгдээр миний найман дүрийг шүтэж санасан бодсоноо нэн даруй сонсго. Хайхархгүй сууж та нарын царайг харж, та нарыг эрхэмлэн хүндэтгэхийг хүлээж байгаа хөөрхий монголчуудын чухал явдлыг саатуулж хэрхэвч болохгүй"<sup>7</sup> гэжээ. Эдгээр дурьдан буй бодитой баримт бол тэр үеийн Монголын нийгэм улс төрийн амьдрал үнэхээр өөрчлөгджэй байгааг бүрэн ухааран үнэндээ тэмцэлд уриалсан шинжтэй байх юм. Хүрээнд сууж байсан Оросын консул Любагаас гадаад хэргийн яаманд илгээсэн нууц албан мэдээлэл ийнхүү тодорхойлжээ. Тэр нь Жавзандамба хутагт Монголыг эдүгээ эрх чөлөө, үйл хэргийг манлайлагч хутагт мөн<sup>8</sup> гэжээ. Тэгвэл монголын эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэлд хаант Орост түшиж, зэрэг өөдрөг харьцааг барих бодлого чиглэлийг үндэслэгч нь Богд хаан байжээ. Тиймээс ч олон нэртэй Оросыг талархагчид /Ханддорж, Намнансүрэн/ олноор төрж чадсан нь улс төрийн бие даасан хүчин болон тэмцжээ. Захидалд дурьдсан санаа хэрэгжиж хаант Орост 1912 оны Ханддорж Чин Вангийн, 1913 онд сайн ноён хан Намнансүрэн нарын айлчлалт, 1912 оны Монгол-Оросын хэлэлцээрээс үзэхэд хаант Орос үнэхээр үүнийг маш нарийн ашиглаж нөлөөндөө баттай оруулан "ивээн тэтгэгч, түшиг улс"<sup>9</sup> болжээ. Хаант Оросыг түших бодлого 1911-1912 онд хөдөлгөөний ялалтанд гадаад дэмжих хүчин болсон бөгөөд хөдөлгөөнд чухал байр эзэлсэн байна. Захидлын гурав дахь хэсэгт санаа бодлоо маш нарийн тайлбарласан байна. Тэр нь стратеги тактикийн шинжтэй гэмээр. "Их Орос улсын их Цагаан хаан эрдэм өршөөл аугаа хүчин нэн их дээр шарын шашныг бадруулж буян чуулганыг хязгаарлашгүй хурах тулд урд ноёдын гүйснаар их улсад шүтэж бага улсын ёсоор харилцан тусалцваас бидний хуучин хэв суртал алдагдахгүй бөгөөд шарын шашин нэн бадарч ашид амар тайвнаар баймуй<sup>10</sup> хэмээн тов тодорхой илэрхийлжээ. Үүнд Их Орос улсын хүчин аугаа их гэдгийг ихэд зөвшөөрөн тэмдэглэжээ. Энэ хэсгийн гол хэсэг нь тусгаар тогтносон Монгол улсын гадаад бодлогыг их улсад шүтэж бага улсын ёсоор харилцан туслалцах хэмээн түшин тусгаар тогтоход яруу тодорхой хэмжээ энэ бол хэзээ

<sup>6</sup> Ардын эрх сонин. 1992

<sup>7</sup> Энэхүү эшлэлийг И.Цоодолын "Хөдөлмөр" сонинд нийтлүүлсэн өгүүллэгээс авав.

<sup>8</sup> Утга зохиол, урлаг сонин. 1990.IV.6 №15 /1749/ (орчуулгаас дам иш татав).

<sup>9</sup> МУИС-ийн ЭШБ. Түүх III. № 228 /23/ 2004. УБ., тал 61

<sup>10</sup> УТА. А4-1-25,2

Ч Оросын хараат дагаар орон байхгүйгээ бол харилцан туслалцах тухайгаа дурьдсан ч үүнийг нотолно. Ингэж Бага улсын ёсоор тусгаар тогтносон, үндэсний улсыг байгуулах зорилтоо ил тод дурьджээ. Манж хятадын эрхшээлээс гараад Оросын эрхшээлд хэзээ ч орохгүйгээ шуудхан хэлсэн хэрэг байлаа. Захидлын энэхүү санаа, зорилт, биелэлт олон улсын харилцаа, дипломатын түүхэнд нэг цоо шинэ бие даасан зарчим бий болгожээ. Эл захидлаас хийж болох чухал дүгнэлт бол Богдыг тойрон хүрээлэгчид (хошуучлагчид) нэгэнтэй тодорч улс төрийн бүлэглэл бий болж 1900-1910-аад онууд гэхэд идэвхтэй ажиллаж эхэлсэн гэж үзэж болмоор байна. Энэхүү Богдыг тойрон хүрээлсэн улс төрийн бүлэглэл хожмын ардын хувьсгалчдын /Д.Сүхбаатар/ хэлсэн "Хүрэн нам" гэгч байж болохыг үгүйсгэх аргагүй. Ингэж үзвээс эл захидал Богд Жавзандамба хутагтын нэр дээр улс төрийн бүлэглэлийн /хүрэн нам/ санаа зоригийг илэрхийлсэн түүхэн баримт бичиг мөн байна.

МАХН байгуулагдахаас арван хэдэн жилийн өмнө дээдсийг хамарсан улс төрийн бүлэглэл /нам/ бий болжээ. Монголд "нам нийлэх" гэдэг үг бий. Захидалд миний санал хэмээн Өвөр монголд бидний адил үндэсний үзэлтнүүд, улс төрчид байдгийг дурьдаад тэднийг хаант Оросын зүгээс дэмжиж түшин тусгаар тогтносон бага улс болоход нь анхаарахыг хүсжээ. "... олон улсын хуульд аливаа төр бага болвоос чийрэг их улсыг түшиж өөртөө тогтнох, ... чийрэг их болбоос дор бага улсыг тэтгэн туслах ёс буй тул учрыг гаргаж бичиг өргөн"<sup>11</sup> тусгайлан жанжин Чин Ван Ханддорж лам Цэрэнчимэд түшмэл Хайсан нарыг зарсны тулд Их хаан үнэн байдал төлөвийг нэвт тольдон ахуу өршөөлөөр нийгүүлсэн үзэж даруйханаа хамгаалан туслахыг Их хаанд бороог хүсэх мэт сүслэн гүйж чин үнэнийг илрүүлэн өчүүхэн бэлэг сэлтийг хичээнгүйлэн өргөв<sup>12</sup> гэжээ. Их улсыг түшин бага улсын ёсоор орших бодлогоо олон улсын хэмжээнд хэрэгжүүлэх асуудал өргөн хүрээг хамарч ирээдүйн улсынхаа гадаад бодлогоо тод томруун тавьсан нь сонин байна. Энэхүү их улсыг түшин бага улсын ёсоор орших хэмээсэн нь олон улсын харилцаанд цоо шинээр дэвшүүлсэн зүйл гэж үзэж болно. Тэрхүү тогтох бага улсын төр нь шашин төрийг хослон баригч хэмжээгүй эрхт хаант улс байхаар томъёолсон нь бас л цоо шинэ зүйл боллоо. Захидалд дурдсан эдгээр санаа бодлого хэрхэн хэрэгжиж биелсэнийг дараах хэрэг явдууд үнэн зөв байсныг нотолно.

1921-1924 онд ч хэмжээт эрхт хаант улсын хэлбэрээр оршиж байсан нь ч үүний уламжлал болон давхар нотолно. Их улсыг Түшин тусгаар тогтносон бага улсын төрийн хэлбэр нь шашин төрийг хослон баригч төр байхаар тогтоосон нь олон улсын төрийн түүхэнд онцгой байр суурь эзлүүлж, төрийн цоо шинэ хэлбэрийг томъёолжээ. Захидлын учрыг тайлах гэсэн өчүүхэн санаа оролдлого ийнхүү төгсч байна. Энэ баримтыг улам гүнзгийрүүлэн судлах нь чухал бөгөөд түүний хавсралт 21 зүйл бичгийг нарийн нягталбал одоо ч улс төрийн их ач холбогдолтойг анхаарах нь чухал. Нэгэн зүйл, Их улсыг түшиж харгалzan туслалцаж бага улсын ёсоор оршин тогтнохоо тодорхойлсон нь чухамдаа даяаршлын нэхцөлд Монгол орон хэрхэн оршин тогтох арга замаа илэрхийлсэн аж. Түших, харилцан туслалцах гэдэг нь Оросын нөлөө зайлбаргүй гэдгийг мэргэн ухаарч зөвшөөрч бас биеэ авч үлдэх замаа ч захидалд тодорхойлжээ. Энэ бол нүүдлийн ба суурьшлын хоёр соёлын харилцан нөпөөлөл явагдахыг зүй тогтолтой үзэгдэл хэмээн хүлээн зөвшөөрчээ. Түүний хамт монгол үндэстэнийг нэгтгэх, төвд тэмүүлэх хүчин хөдлөх ба Ар Өвөр Монгол Дөрвэдийг нэгтгэсэн нэгдсэн Их Монгол улсыг байгуулах тухай Халх төвийн үзэл цухалзаж байгаа нь ажиглагддаг. Дараагийн хэрэг явдал хөдөлгөөнд Халхчууд гол төв болсон байх бөгөөд Халх төвийн үзэл, бодлого,

<sup>11</sup> УТА. 4-1-25,2<sup>12</sup> УТА. 4-1-25,2

үйл ажиллагааг түүхэн тухай үе бүрд ямар ач холбогдолтой, тэргүүлэх үндэстэн болохыг чиглэн гүн судалмаар болжээ.

**Abstract:** We can assume that the letter from Bogd Javzandamba to the Russian tsar clearly expressed the determination for running the policy for "obtaining independence with the support of the Great Nation" and "mutual support base on worshipping the Great Nation and existing as a small nation". Mongolian leaders of those times believed that the only way Mongolian could obtain independence is to get support of the Great Nation (Russia).